



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар A/306

Мөрөн сүм

Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг
хүлээн авах, хүлээлцэх ажлын хэсгийн
бүрэлдэхүүнийг томилж, ажиллуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайд нарын 2005 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 101/189/194 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн Арбулаг сумын Хавтага багийн “Буянтын адаг” нэртэй газарт гаргасан инженерийн хийцтэй уст цэгийг ашиглалтад хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар томилсугай.

2. Уст цэгийн ашиглалт, засвар үйлчилгээ, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Арбулаг сумын Засаг даргад үүрэг болгосугай.

3. Бэлчээрийн гүний худаг гаргахаар байгуулсан гэрээний дагуу комисс ажиллах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас зарцуулахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга (Я.Эрхэмбаяр)-д даалгасугай.

4. Комиссын гишүүдэд чанаргүй, уст цэг хүлээж авсан тохиолдолд хариуцлага тооцохыг анхааруулсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН



Аймгийн Засаг даргын 2022 оны 09
дүгээр сарын 17.-ны өдрийн A/306.. дүгээр
захирамжийн хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР АРБУЛАГ СҮМАНД
ШИНЭЭР ГАРГАСАН ИНЖЕНЕРИЙН ХИЙЦТЭЙ УСТ ЦЭГИЙГ
АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВАХ КОМИССЫН БҮРЭЛДХҮҮН

Комиссны дарга: Б.Бямбасүрэн (Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал
үржлийн албаны дарга)

Гишүүдэд:

Д.Чинзориг- (Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн Хүнс,
хөдөө аж ахуйн бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн)

Б.Даваасүрэн (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын
улсын байцаагч)

Д.Нямбат (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

Д.Өнөрбаяр (Тухайн нутаг дэвсгэрийн хариуцсан Усны сав газрын захиргааны
төлөөлөл)

Ц.Бэхбаяр (Аймгийн Орон нутгийн өмчийн төлөөлөл)

Б.Гантулга (Арбулаг сумын Засаг дарга)

Н.Балжинням (Арбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Бэлчээр, газар
тариалан хариуцсан мэргэжилтэн)

К.Намхайжамц (Орон нутгийн иргэд болон Төрийн бус байгууллагын төлөөлөл)

Н.Баттулга (Хөвсгөл-Цэнгэг ус ХХК-ий захирал)

Нарийн бичгийн дарга: Т.Пүрэвхүү (Хүнс, хөдөө аж ахуйн газрын худаг, ус
хариуцсан мэргэжилтэн)

--оOо--